



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 669

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаанд сэргээн засварлах боломжгүй ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 5 нэрийн нийт 100,714,000 /нэг зуун сая долоон зуун арван дөрвөн мянга/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан чиргүүл, автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн захирал Ш.Отгонжаргалд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан үндсэн хөрөнгийг сургалтын дадлагын хичээлд ашиглахаар байгууллагадаа үлдээж, эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн
6.6.9 дугаар тогтоолын хавсралт



Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй акталж, данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Ландкрузер-80, 30-81 ГСА, арал№ JT114PJ8007022577	1996/ 2001	7,000,000
2	Трайллерын толгой, 35-67 ГСА, Арал№KMEDC18YPNVU5648	1992/ 2001	18,000,000
3	Трайллерын чиргүүл,	2008/ 2008	20,250,000
4	Экскаватор, 57-88 УБ,	2005/ 2005	54,264,000
5	Чиргүүл /пад/	2013/ 2013	1,200,000
	Нийт дүн		100,714,000 /нэг зуун сая долоон зуун арван дөрвөн мянга/